



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын II баг

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ “ШИНЭ ХӨДӨӨ” ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ ИРЭЭГҮЙ БАЙХАД ХҮЛЭЭН АВСАН АКТААР БАТАЛГААЖУУЛЖ САНХҮҮЖИЛТ ОЛГОСОН
БАЙНА

АУДИТЫН КОД: ХОА-2024/18-ШТА-ГА

Ховд хот

2024 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Эрдэнэцэцэг

Утас: 70432545 Цахим хаяг: erdenetsetsegd@audit.gov.mn

Аудитор: А.Нарандэлгэр

Утас: 7043-2545 Цахим хаяг: narandelgerA@audit.gov.mn

Аудитор: Ц.Бадрал

Утас: 7043-2545 Цахим хаяг: badralts@audit.gov.mn

Аудитор: Н.Батжаргал

Утас: 7043-2545 Цахим хаяг: batargalN@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар..... 3

Хүснэгтийн товъёг 3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл 4-5

БҮЛЭГ 1: Улсын төсвөөс санхүүжүүлэх төсөл арга хэмжээг холбогдох журмын дагуу боловсруулж Сангийн яаманд саналаа хүргүүлэн ажилласан байна.....6

- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний төсөвт өртөг анх байгуулсан гэрээний үнийн дүнгээс 13.196.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна

БҮЛЭГ2: Хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй зарим төсөл арга хэмжээний төсөвт өртөгт суугдсан ажлыг дутуу гүйцэтгэсэн зөрчил дутагдал давтагдсаар байна.....11

- ✓ Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь бүрэн гүйцэтгүүлж, ажлын даалгаврын дагуу хүлээн аваагүй байна

БҮЛЭГ3: Зарим барилга байгууламж, техник тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар ашиглаагүй, нийлүүлсэн тоног төхөөрөмж ашиглалтгүй хадгалагдаж байгаа нь төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна..... 19

- ✓ Хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрээгүй, өмнөх онд өгсөн зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ :

Он дамжин хэрэгжиж байгаа зарим хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хангалтгүй, гүйцэтгэгч тал гэрээний үүргээ биелүүлээгүй, захиалагч тал гэрээний биелэлтийг тооцож ажиллаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:.....23

ХАВСРАЛТУУД:

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ: 25

САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:28

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын их хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗД	Засаг дарга
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТХЗ	Техник хяналтын зардал
СЗДТГ	Сумын Засаг даргын тамгын газар
ТББ	Тендерийн баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАХ	Төсөл арга хэмжээ
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУ	Монгол улсын
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХНХЯ	Хөдөлмөр нийгэм хамгааллын яам

Хүснэгтийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Зураг төсөвгүй батлагдсан арга хэмжээ	6
Хүснэгт 2	Төсөвт өртөг нэмэгдсэн төсөл арга хэмжээ	7
Хүснэгт 3	Хэрэгжсэн төсөл арга хэмжээ	8
Хүснэгт 4	Эрх шилжээгүй төсөл арга хэмжээнээс дуусаагүй барилга байгууламж	12

Графикийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Батлагдсан төсөл арга хэмжээ	8
График 2	Зураг төсөв хийсэн аж ахуйн нэгжүүд	10
График 3	Захиалагчийн болон зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн санхүүжилт	12

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолд тусгасны дагуу аудитыг хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймагт 2023 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж Аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх, • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх, • Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх
Аудитын хамарсан хүрээ:	Аудитад Ховд аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар УИХ-аас 2022 онд батлагдсан 53 төсөл арга хэмжээнээс 2023 онд 46 төсөл, арга хэмжээг он дамжуулан хэрэгжүүлэхээр батлагдсан байна. Аймгийн засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, сум, байгууллага болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч ААН-ийг үйл ажиллагааг хамруулан төлөвлөлт, судалгаа, шинжилгээний баримт, ажлын тайлан, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгч байгууллагуудтай хийсэн гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилт, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагуудын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, үр дүнгийн хүрээнд аудитыг гүйцэтгэв.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуултын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйл цуглуулан, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Тэргүүлэх аудитор Х.Болдбаатар хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн хэрэгжүүлж, Ахлах аудитор Д.Эрдэнэцэцэг, аудитор А.Нарандэлгэр, Н.Батжаргал, Ц.Бадрал нар 2024 оны 03-р сарын 25-наас 04-р сарын 25-нийг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгаагдах мэдээлэл:	Аудитын тайланг Төрийн аудитын газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулан, аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, Үндэсний аудитын газарт нэгтгүүлэв.
Хүндрэл бэрхшээл:	Аудитын тайланд хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй эрх шилжээгүй төсөл арга хэмжээний судалгаа ирээгүй учир газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл, инженер геологийн дүгнэлт зэрэг нь төлөвлөлтийн шаардлага хангаж, хууль батлагдахаас өмнө баталгаажсан эсэхэд дүгнэлт хийх боломжгүй байна. Аудитыг гүйцэтгэх хугацаанд Төсвийн тухай хуульд заасан санхүүгийн тайлан баталгаажуулах хугацаа давхцаж, орон нутагт ажиллах хүчний нөөц дутагдалтай байсан нь аудитыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байлаа.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Ховд аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжиж ирсэн 246.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 46 төсөл арга хэмжээнд 2023 онд 87.3 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Тайлант онд эрх шилжсэн 81.6 тэрбум төгрөгийн өртөгтэй 24 төсөл арга хэмжээний 32.1 тэрбум төгрөг, эрх шилжээгүй 164.5 тэрбум төгрөгийн 22 төсөл арга хэмжээний 55.2 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 46 төсөл арга хэмжээний 33 төсөл арга хэмжээ бүрэн дуусахаар, 13 төсөл арга хэмжээ нь он дамжин хэрэгжихээр төлөвлөгдөн батлагдаж 51.1 хувь буюу 24 төсөл арга хэмжээ нь эрх шилжин хэрэгжиж, 48.9 хувь буюу 22 төсөл арга хэмжээ нь эрх шилжээгүй хэрэгжсэн байна.

Тайлант онд эрх шилжсэн хөрөнгө оруулалтад 32.1 тэрбум төгрөгийг зарцуулж 2.3 тэрбум төгрөгийг Засгийн газрын 2022 оны 495 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын 7/02 дугаар тогтоолын дагуу барьцаа дансанд төвлөрүүлсэн байна.

Ховд аймгийн Засаг дарга нь “Алсын хараа-2050” урт хугацааны хөтөлбөр, “Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг хөгжлийн тулгуур баримт бичгүүдэд үндэслэн “Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, “аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг боловсруулан аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ховд аймгийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг уламжлалт болон эрчимжсэн хөдөө аж ахуй, өндөр уулын бүсийн аялал жуулчлалаар тодорхойлж, хөрөнгө оруулалтууд хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн цогцолборыг хөгжүүлэх, улсын дэд бүтцийн хөндлөн тэнхлэгийн зам, боомтыг барьж дуусгах зорилтын хүрээнд чиглэгдэж эдийн засгийн өсөлт бий болох, ажлын байр нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зэрэг өөрчлөлтүүд бий болохоор байна.

Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүний хөгжлийн бодлого зорилтын хүрээнд эрүүл мэнд, биеийн тамир спорт, боловсрол, үндэсний бахархал өв соёлын чиглэлээр сургууль, цэцэрлэг, кино болон хөгжимт драмын театр, эрүүл мэндийн төвүүд, спорт заал зэрэг 20, бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийн 23, засаглалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төсөвт байгууллагын барилга байгууламж 3 нийт 46 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна.

БҮЛЭГ 1: Улсын төсвөөс санхүүжүүлэх төсөл арга хэмжээг холбогдох журмын дагуу боловсруулж Сангийн яаманд саналаа хүргүүлэн ажилласан байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний төсөвт өртөг анх байгуулсан гэрээний үнийн дүнгээс 13.196.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна

1.1 Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 оны төсвийн жилд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгуулалтын жагсаалтад батлагдсан өмнөх оноос шилжих хөрөнгө оруулалт 46 төсөл арга хэмжээ байна. Барилгын зураг төсвийг иж бүрэн боловсруулж, магадлалаар баталгаажуулаагүй нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэл удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх үндсэн шалтгаан болж байна.

МУ-ын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийг шинэчлэн баталсан байна. Тус тогтоолын 6.3-т "Барилгын тухай хуулийн 25.2¹, 25.3², 25.5³-д заасан барилга байгууламжийн зураг төсөлд заавал магадлал хийнэ" гэж заасантай нийцсэн байна.

Хүснэгт №1 Зураг төсөвгүй батлагдсан арга хэмжээ

	Төсөл арга хэмжээ	Эхлэх	Дуусах	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний үнийн дүн		
					Анхны	Сүүлийн	Нэмэгдсэн дүн
1	X.1.1.1 Цэцэрлэгийн барилга /Ховд, Жаргалант сум, Баатархайрхан баг, 10 дугаар цэцэрлэг/	2020	2023	"Турлиахт" ХХК	1,040.1	1,367.8	327.7
2	X.1.1.2 Дотуур байрны барилга, 150 ор /Ховд, Манхан сум, Төгрөг гол баг/	2022	2024	"Ховд шинэ Асар" ХХК	3,135.2	3,184.9	49.7
3	X.1.1.2 Цэцэрлэгийн барилга, 75 ор /Ховд, Жаргалант сум, Алагтолгой баг/	2022	2023	"Бүтээмж тауэр" ХХК	1,909.8	2,107.1	197.3
4	X.1.1.3 Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Ховд, Жаргалант сум, 12 дугаар баг, Малчны хороолол/	2022	2024	"Баганат Орд" ХХК	4,801.9	5,046.5	244.6
5	XI.1.5 Кино театрын барилга /Ховд, Жаргалант сум/	2022	2023	"Чандмань Уушир" ХХК	2,449.0	5,432.9	2,983.9
6	XIII.1 Хүнс, хөдөө аж ахуйн газар, лабораторийн барилга /Ховд, Жаргалант сум/	2021	2023	"Саруул цамхаг" ХХК	1,721.8	2,937.4	1,215.6
7	XIX.1 Спорт заалны барилга, 250 суудал /Ховд, Цэцэг сум/	2020	2023	"Цагаан бөлбөө" ХХК	1,056.1	1,711.0	654.9
НИЙТ ДҮН				-	16,113.9	21,787.6	5,673.7

Зураг төсөв нь магадлалаар баталгаажуулаагүй 16.113.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ 5.673.7 сая төгрөгөөр нэмэгдэж 21.787.6 сая төгрөг болж өссөн байна.

1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг өмнөх онд салбарын байгууллагуудаас ирүүлсэн саналуудыг үндэслэн Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам"-ын 4.1-т заасны дагуу шилжих буюу

¹ Магадлалыг дараах зураг төсөлд хийнэ:

² Энэ хуулийн 25.2 дахь хэсэгт гадаад улсын хуулийн этгээдийн боловсруулсан барилга байгууламжийн зураг төсөлд нэгэн адил хамаарна.

³ Барилгын ажлын явцад барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгаж боловсруулсан зураг төсөлд дахин магадлал хийлгэнэ.

хэрэгжүүлж буй төсөл, их засварын төсөл, шинээр хэрэгжүүлэх төслийн төрлүүдээр эрэмбэлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга, их засвар, тоног төхөөрөмжийн саналын жагсаалт гарган publicinvestment.gov.mn цахим системд оруулсан байна.

Тендерийн ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, сонгон шалгаруулалтын журмыг зөв сонгож, хууль журмын дагуу үнэлгээний хороо байгуулан тендер шалгаруулалтыг хуулийн хугацаанд тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид хүргүүлэн ажиллаж байна.

1.3. Барилга байгууламжийн ТЭЗҮ, зураг төслийг холбогдох хууль тогтоомж, барилгын норм ба дүрэм, төсвийн үнэ бүрдэл, төсөв зохиох дүрмийн дагуу магадлалаар баталгаажуулсан эсэхийг мэргэжлийн шинжээч оролцуулаагүй тул нотлох боломжгүй байна.

1.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний төсөвт өртөг анх байгуулсан гэрээний үнийн дүнгээс 13,193.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Эрх шилжсэн төсөл арга хэмжээний ажлаас төсөвт өртөг нэмэгдсэн ажлуудыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1 төсөвт өртөг нэмэгдсэн төсөл арга хэмжээ

/сая төгрөгөөр/

Д/Д	Хуулийн дугаар	Төсөл арга хэмжээ	Эхлэх	Дуусах	Гүйцэтгэгч байгууллагын нэр	Гэрээний үнийн дүн			Магадлалын дүгнэлт	
						Анхны	Сүүлийн	Нэмэгдсэн дүн		
1	III.1.26	Багийн төвийн барилга /Ховд, Буянт сум, Наранхайрхан баг/	2020	2024	"Авга ач нар" ХХК	246.1	857.0	610.9	Магадлалын дүгнэлт-1935/2022-423101733	
2	IX.1.37	Инженерийн шугам сүлжээний өргөтгөл /Ховд, Зэрэг сум/	2020	2023	"Тулгат багана" ХХК	755.6	833.3	77.7	Магадлалын дүгнэлт 88-0289/2022	
3	IX.1.58	Гэр хорооллын цэвэр бохир усны шугам, сүлжээ /Ховд, Жаргалант сум, Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг/	2021	2023	"Ховдын Өргөө" ХХК	9,380.0	9,489.6	109.6	Магадлалын дүгнэлт-88-487/2022	
4	X.1.1.125	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Ховд, Жаргалант сум, 9 дүгээр цэцэрлэг/	2020	2023	"Ганбүрэн" ХХК	2,442.2	3,367.9	925.7	Магадлалын дүгнэлт 88-180/2022	
5	X.1.1.128	Цэцэрлэгийн барилга /Ховд, Жаргалант сум, Баатархайрхан баг, 10 дугаар цэцэрлэг/	2020	2023	"Турлиахт" ХХК	1,040.1	1,367.8	327.7		
6	X.1.1.217	Багшийн хөгжлийн төвийн барилга /Ховд, Жаргалант сум/	2022	2024	"Би Эм жи Юу" ХХК	2,716.9	7,226.7	4,509.8	Магадлалын дүгнэлт 1000/2022	
7	X.1.1.230	Дотуур байрны барилга, 150 ор /Ховд, Манхан сум, Төгрөг гол баг/	2022	2024	"Ховд шинэ Асар" ХХК	3,135.2	3,184.9	49.7		
8	X.1.1.249	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Ховд, Жаргалант сум, Алагтолгой баг/	2022	2023	"Бүтээмж тауэр" ХХК	1,909.8	2,107.1	197.3		
9	X.1.1.320	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Ховд, Жаргалант сум, 12 дугаар баг, Малчны хороолол/	2022	2024	"Баганат Орд" ХХК	4,801.9	5,046.5	244.6		
10	XI.1.57	Кино театрын барилга /Ховд, Жаргалант сум/	2022	2023	"Чандмань Уушир" ХХК	2,449.0	5,432.9	2,983.9		
11	XII.1.1.34	Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Ховд, Жаргалант сум, Баатархайрхан, Бичиг баг/	2020	2023	"Кеналхан" ХХК	870.0	957.6	87.6	Магадлалын дүгнэлт-257/2022-УИХ88-68704392	
12	XII.2.1.8	Чоно харайхын гүүр /Ховд, Дөргөн сум/	2020	2023	"Хотгор зам" ХХК	1,487.6	1,834.1	346.5	Магадлалын дүгнэлт-196/2022-УИХ88-62222922	
13	XIII.1.11	Хүнс, хөдөө аж ахуйн газар, лабораторийн барилга /Ховд, Жаргалант сум/	2021	2023	"Саруул цамхаг" ХХК	1,721.8	2,937.4	1,215.6		
14	XIX.1.13	Спорт заалны барилга, 250 суудал /Ховд, Дарви сум/	2020	2023	"Богоч констракшн" ХХК	1,000.9	1,451.3	450.4	Магадлалын дүгнэлт 88-205/2022	
15	XIX.1.18	Спорт заалны барилга, 250 суудал /Ховд, Цэцэг сум/	2020	2023	"Цагаан бөлбөө" ХХК	1,056.1	1,711.0	654.9		
16	XIX.1.19	Спорт заалны барилга /Ховд, Жаргалант сум, Бугат, Хайрхан баг/	2020	2023	"Элбэг гүн" ХХК	1,039.4	1,441.1	401.7	Магадлалын дүгнэлт 88-378/2022	
НИЙТ ДҮН						-	36,052.6	49,246.2	13,193.6	-

Тайлант онд хэрэгжих 16 төсөл арга хэмжээ 36.052.6 сая төгрөгийн төсөвт өртгөөс 49.246.2 сая төгрөг болж нэмэгдэж санхүүжилтийг хуулийн дагуу бүрэн олгосон байна.

1.5. Ховд аймагт 2023 онд он дамжин хэрэгжихээр батлагдсан 46 төсөл, арга хэмжээ нь Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Монгол Улсын “2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” зэрэг урт болон дунд хугацааны бодлоготой уялдсан байна.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг дээрх хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцүүлэхээс гадна хүн амын нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлж бүс, орон нутгийн хөгжлийн уялдааг хангуулах зорилтын хүрээнд улсын төсвөөс санхүүжүүлэх төсөл арга хэмжээг холбогдох журмын дагуу боловсруулж Сангийн яаманд саналаа хүргүүлэн ажилласан байна.

1.6. Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 46 төсөл, арга хэмжээг төсвийн тухай хуулийн 2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад бүрэн тусгасан байна.

Тайлант онд эрх шилжсэн 24, эрх шилжээгүй 22 төсөл арга хэмжээний ажлаас 2023 онд



санхүүжих БХБ-ын сайдын багцад 4 ажлын 5021.9 сая, БСШУ-ны сайдын багцад 13 ажлын 15039.1 сая, ЗТХ-ийн сайдын багцад 4 ажлын 20014.7 сая, ЗГХЭГ-ын багц 4 ажлын 2992.1 сая, МУ-ын сайдын багц 4 ажлын 2603.4 сая, Соёлын сайдын багц 2 ажлын 4444.9 сая, ХЗДХ-ийн сайдын багц 2 ажлын 4209.4 сая, ХААХҮ-ийн сайдын багц 5 ажлын 17660.2 сая, Эрүүл мэндийн сайдын багц 3 ажлын 1554.0 сая, Эрчим хүчний сайдын багц 5 ажлын 13686.0 сая төгрөг

нийт 87225.8 сая төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжсэн байна.

1.7. Тайлант онд шинээр эхлэх 1 хөрөнгө оруулалт, өмнөх оноос эрх шилжиж ирсэн 24, эрх шилжиж ирээгүй 22 төсөл, арга хэмжээний санхүүжилт нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁴-д заасны дагуу төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад багтсан байна.

Хүснэгт-3 Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ

№	ТАХ-ний төрөл	ТАХ-ний тоо	Эрх шилжсэн		Эрх шилжээгүй		ТАХ-ний тоо	ДҮН	
			Төсөвт өртөг	2023 онд санхүүжих	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих		Төсөвт өртөг	2023 онд санхүүжих
1	Барилга байгууламж	23	74,611.4	25,466.0	21	164,250.3	44	238,861.70	80,481.70
2	Тоног төхөөрөмж	1	7,000.0	6,664.0	1	259.2	2	7,259.20	6,863.20
3	Их засвар						0	-	-
ТАХ-ний нийт дүн		24	81,611.4	32,130.0	22	164,509.5	46	246,120.9	87,344.9

⁴ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

Тайлант онд эрх шилжиж ирсэн 24 төсөл арга хэмжээний зардалд 32.130.0 сая төгрөг батлагдсанаас 31.725.3 сая төгрөг төсвийн санхүүжилт ирж 404.7 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна. Тухайлбал:

- ✓ БШУС-ын багцад батлагдсан Манхан сумын сургуулийн дотуур байрны санхүүжилт 100.7 сая,
- ✓ ХХААХҮЯ-ны сайдын багцад батлагдсан Шинэ хөдөө төслийн багцын санхүүжилт 184.7 сая,
- ✓ Орон нутгийн хөгжлийг дэмжих багцын үүл буудах сумын санхүүжилт 100.0 сая, /тусгай зөвшөөрлөөр хилээр орж ирдэг учир буцсан/
- ✓ Батлагдсан төсөв, гэрээний үнийн зөрүү 19.2 сая төгрөгийн санхүүжилт бүрэн ирээгүй байна.

1.8. Төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нь барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах, гүйцэтгэл гаргаж санхүүжилт авах хүсэлтийг аймаг Засаг даргад ирүүлснийг үндэслэн төсөл, арга хэмжээг хүлээж авах, гүйцэтгэлд хяналт тавих ажлын хэсэг болон улсын комиссын бүрэлдэхүүнийг томилон ажиллуулж байна.

Комисс нь холбогдох хууль, дүрмийн дагуу зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт, техникийн хяналтын нэгдсэн дүгнэлтүүд гараагүй байхад үүрэг даалгаврын биелэлтээр ТАХ-г хүлээн авах, гүйцэтгэлийн санхүүжилтийг ажлын гүйцэтгэлээр санхүүжүүлээгүй зөрчил давтагдсаар байна. Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5⁵, Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 4 дүгээр зүйлийн 4.2.4⁶, 4.1.4⁷-д заасны дагуу төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд уялдуулан санхүүжүүлэхгүй байна.

Аудитын илрүүлэлт

- Олон угсаатны театрын барилга /Ховд, Жаргалант сум/-ын ажлын гүйцэтгэлийг бодит гүйцэтгэлээр гаргаагүй, үүрэг даалгаврын биелэлтээр өгөгдсөн ажлууд хэрэгжээгүй 1.457.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон
- Багшийн хөгжлийн төвийн барилга /Ховд, Жаргалант сум/-ын ажлын гүйцэтгэлийг бодит гүйцэтгэлээр гаргаагүй 390.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон
- Жаргалант сумын 240 ортой хүүхдийн 9-р цэцэрлэгийн ажлыг гүйцэтгэсэн Ган бүрэн ХХК нь дулааны тоолуур суурилуулаагүй, гадна тохижилтын ажлыг гүйцэтгээгүй, комиссоос өгсөн үүрэг даалгавар хэрэгжээгүй байхад хүлээн авч санхүүжилт бүрэн олгосон

БҮЛЭГ 2: Хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй зарим төсөл арга хэмжээний төсөвт өртөгт суугдсан ажлыг дутуу гүйцэтгэсэн зөрчил дутагдал давтагдсаар байна

Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь бүрэн гүйцэтгүүлж, ажлын даалгаврын дагуу хүлээж аваагүй байна

2.1. Барилга, байгууламжийн зураг, төсөл зохиох ажлын даалгаврыг салбарын бодлого, хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлага, геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл зэрэгт үндэслэн боловсруулж, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний архитектур,


⁵ Захиалагч энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагад барилга байгууламжийг ашиглалтад оруулахаар хүсэлт гаргах бөгөөд түүнд дараах баримт бичгийг хавсаргана:

⁶ Захиалагч барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон барилга угсралтын ажлын календарьчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр илэрхийлж, энэ журмын холбогдох хавсралтад заасан маягтын дагуу гаргана

⁷ Санхүүжилтийн гүйцэтгэлийг тухайн төслийн зураг төсөл болон төсвийн дагуу барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг

үндэслэн барилга угсралтын гэрээнд тусгасан үе шатны ажил тус бүрээр гаргаж, магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй тулган шалгаж, хянан баталгаажуулна.

төлөвлөлтийн даалгаврыг барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн дагуу аймгийн ерөнхий архитектор баталж, зураг төсөв гүйцэтгэгчид хүргүүлж байна.



Зураг төслийг барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд Барилгын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу боловсруулсан ч зарим ажлын тоо хэмжээ өөрчлөгдөх, нэмэлт ажлууд гарсаар байна. Энэ нь төсөл, арга хэмжээг магадлалаар баталгаажсан зураг төсөвгүйгээр, тойм дүнгээр төсөвт өртгийг баталж худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас шалтгаалж төсөл арга хэмжээ

хугацаандаа ашиглалтад орохгүй удаашрах нөхцөл байдал үүсэж байна.

Тайлант онд хэрэгжих төсөл арга хэмжээний судалгаанаас үзэхэд 2023 онд санхүүжих 28.009.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл арга хэмжээний зураг төсвийг, зураг төсвийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 12 аж ахуйн нэгж хөрөнгө оруулалтын зураг төсвийг гүйцэтгэсэн байгаагаас хамгийн их зураг төсөв аж ахуйн нэгж Алтайн газрын хүч ХХК байна.

Аудитын илрүүлэлт

- Жаргалант сумын Бичигт багт баригдсан 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын зураг төсвийг магадлалаар оруулаагүй байхад ХАА зохион байгуулснаас тоо хэмжээний зөрүү үүссэн бөгөөд үүнээс шалтгаалж гүйцэтгэгч тоглоомын бетон зам талбайг 324 м²-аар дутуу гүйцэтгэсэн,
- Жаргалант сумын Алагтолгой багт баригдсан 75 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын магадлалшгүй ажлаар тухайн барилгад хамааралгүй шугамын потки өргөтгөсөн, зохиогчийн зөвшөөрөл аваагүй,
- Зураг төсөв боловсруулах байгууллагыг тендер зарлахгүй нэг аж ахуйн нэгж хэт олон зураг хийхээр гэрээ байгуулж байгаа нь зургаа хугацаандаа хүлээлгэн өгөхгүй байх, чанаргүй хийгдэх, зураг төсөвгүй төсөв батлагдах эрсдэл үүсэж байна.

2.2. Техник, тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт туссан үзүүлэлт, тоо хэмжээнээс зөрүүтэй дутуу нийлүүлсэн байна Тухайлбал

Аудитын илрүүлэлт

- Шинэ хөдөө төсөл **Багц-1**: ХАА-н газар тариалангийн тоног төхөөрөмж: 2022 онд 96.0 сая, 2023 онд 5060.0 сая нийт 5156.0 сая төгрөгийн төсөв батлагдсан. Тоног төхөөрөмж нийлүүлэхээр Динатос ХХК гэрээ байгуулж гэрээний дагуу 7 бүлэг тоног төхөөрөмж нийлүүлэхээс 5 төрлийн тоног төхөөрөмж нийлүүлээгүй, 6 ширхэг экскаватор нийлүүлэхээс ажлын даалгавар өөрчилж 1 комбайн хүлээн авсан, 1 ажлын цахилгаан холболтын тоног төхөөрөмж нийлүүлэхээс 6 ширхэг трансформатор хүлээн авч бусад төхөөрөмжийг хүлээн аваагүй, Тоног төхөөрөмж ирээгүй байхад Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 23-ний өдрийн А/356 дугаар захирамжаар томилогдсон 10 хүний бүрэлдэхүүнтэй комиссын 2023.07.03-ны актад гэрээгээр хүлээн авсан үүргээ хэсэгчлэн биелүүлсэн, тоног төхөөрөмжийг хариуцагч байгууллагын мэдэлд бүрэн шилжүүлж ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэв, БНХАУ-ын такешкен боомтод 2023.08.10-ны дотор газар дээр нь хяналт хийж хүлээн авахаар тохиролцов гэсэн акт үйлдэж 4555.1 сая төгрөгийн санхүүжилт бүрэн авсан байна.

- **Багц-2:** ХАА-н хөнгөн үйлдвэрийн тоног төхөөрөмж: Нийт санхүүжилт 1219.0 сая төгрөг. Бодит гүйцэтгэл 1138.9 сая төгрөг. Тоног төхөөрөмж нийлүүлэх 8 ажилд ОБМ машинери сервис ХХК гэрээ байгуулан нийлүүлэхээс 7 ажил хүлээлгэн өгч 1 ажлын 300ш хонь хяргах гар машины ажлын даалгаврыг өөрчилж 25ш гар машин хүлээн авсан байна.
- **Багц-3:** ХАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмж: Нийт санхүүжилт 392.5 сая төгрөг. Бодит гүйцэтгэл 366.3 сая төгрөг. 10 багц тоног төхөөрөмж нийлүүлэхээр Вээст бүүдэн ХХК гэрээ хийсэн. Тус компани 9 багц тоног төхөөрөмж нийлүүлсэн. Цэцгий ялгах машиныг ажлын даалгаврын дагуу нийлүүлээгүй, тоо хэмжээг өөрчилж хүлээн авсан.
- **Багц-4:** Хүлэмжийн аж ахуйн тоног төхөөрөмж нийлүүлэх: Нийт санхүүжилт 232.5 сая төгрөг. 3 төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэхээр Интерворлд ХХК гэрээ байгуулсан. 2 төрлийн тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн. 1 төрлийн 105.0 сая төгрөгийн бороожуулагч систем хүлээлгэн өгөөгүй.
- Цэцэрлэгийн барилга, 240 ор /Ховд, Жаргалант сум, 9 дүгээр цэцэрлэг/-ын ажлыг гүйцэтгэсэн Ган бүрэн ХХК нь,,, сая төгрөгийн /дулааны тоолуур суурилуулаагүй, сүүдрэвч 6ш, хогийн сав 2ш, сандал 8ш, модон хайс барих/ ажлуудыг дутуу хэрэгжүүлсэн
- Ховд сумын Сургуулийн барилгын ажлын нормчлолын сангийн төлбөрийг давхардуулан гүйцэтгэгчийн дансанд олгосон 2.7 сая төгрөг,

2.3. УТХО-аар хэрэгжүүлэх эрх шилжүүлсэн ажлын гэрээг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд гэрээний хугацаанд 27 төсөл арга хэмжээг дуусгаж, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаагүй 31 төсөл арга хэмжээний 2302.9 сая төгрөг барьцаа хөрөнгийн дансанд байна. Ажлаа бүрэн дуусгаж гэрээний дагуу хугацаандаа хүлээлгэн өгөөгүй аж ахуйн нэгжүүдэд хариуцлага тооцох шаардлагатай байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт

- Зэрэг сумын инженерийн шугам сүлжээний өргөтгөл: анхны төсөвт өртөг 798.4 сая төгрөг. Магадлалаар 34.9 сая төгрөг нэмэгдсэн. Нийт төсөв 833.3 сая төгрөг. Бодит гүйцэтгэл 783.1 сая төгрөг. Шалтгаан нь төсөв нэмүүлэх тайлбартай. Төсөө хугацаанд нь бүрэн авсан. БХБЯ/202001024 тоот гэрээг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр нэмэлт гэрээ хийн 2023 оны 8 дугаар сарын 02-ны өдөр дуусгаж ашиглалтад оруулахаар гэрээг шинэчилсэн боловч гэрээний үүргээ биелүүлээгүй, 2023 онд зохиогчийн хяналт хийгдээгүй. Гүйцэтгэгчээс шалтгаалсан ажлын гүйцэтгэл 70% тай, Хугацаандаа хүлээлгэн өгөхгүй байх үндэслэлтэй шалтгаан байхгүй
- Дарви сумын спорт заалны барилга: 250 хүний суудалтай. Анхны өртөг 1196.2 сая төгрөг. Материалын үнийн өсөлтөөр 255.2 сая төгрөг нэмэгдсэн. Нийт төсөв 1451.3 сая төгрөг. Бодит гүйцэтгэл 1305.4 сая төгрөг. Шалтгаан нь төсөв нэмүүлэх тайлбартай. Төсөө хугацаанд нь бүрэн авсан. БСШУСЯ/202001357 тоот гэрээг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр нэмэлт гэрээ байгуулан 2023 оны 8 дугаар сарын 25-нд хүлээлгэн өгөхөөр гэрээг шинэчлэн байгуулсан. Ажлын гүйцэтгэл 50% тай. Гэрээний үүргээ биелүүлээгүй, 2023 онд ажил хийгдээгүй, зохиогчийн хяналт хэрэгжүүлээгүй, хугацаандаа хүлээлгэн өгөхгүй байх үндэслэлтэй шалтгаан байхгүй.
- Цэцэг сумын спорт заал: 250 хүний суудалтай. анхны өртөг 1056.1 сая төгрөг. Нэмэлт гэрээгээр 1711.0 сая төгрөг. Материалын үнийн өсөлтөөр 654.8 сая төгрөг нэмэгдсэн. Нийт төсөвт өртөг нь 1711.0 сая төгрөг. Бодит гүйцэтгэл 1636.6 сая төгрөг. Үлдэгдэл санхүүжилт 74.4 сая төгрөг. БСШУСЯ/202001358 тоот гэрээг 2023 оны 1 дүгээр сарын 16-нд нэмэлт гэрээгээр шинэчилж 2023 оны 7 дугаар сарын 17-ны өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээг шинэчлэн байгуулсан. Гэрээний үүргээ биелүүлээгүй. Шалтгаан нь төсөв хүрэхгүй нэмүүлэх тайлбартай. Ажлын гүйцэтгэл 80% тай. Хугацаандаа хүлээлгэн өгөхгүй байх үндэслэлтэй шалтгаан байхгүй
- Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр багц 6: Төсөвт өртөг 200.0 сая төгрөгөөр Чандмань сумын төвийн гэрэлтүүлэг /04 ВТ/ цахилгаан хийх ажил хугацаандаа хэрэгжүүлээгүй



- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Ховд, Жаргалант сум, Бичигт баг/-ын ажлын хуульд нийцээгүй нэмэлт гэрээ хийсэн, гэрээний хугацаандаа хүлээлгэн өгөөгүй тайлбар ирүүлээгүй

Мөн эрх нь шилжиж ирээгүй үнийн өсөлт, тоног төхөөрөмж ирээгүй шалтгаан нөхцөлийн улмаас хугацаандаа ашиглалтад ороогүй цэвэрлэх байгууламж 1, сургуулийн дотуур байр 1, дэд станцын өргөтгөл 1, халаалтын зуухны өргөтгөл 1, спорт заал 1 нийт 5 барилгын ажил дуусаагүй үргэлжилж байна.


Хүснэгт 4: Хугацаандаа хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	
		Эхлэх	Дуусах
1	Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламж /Ховд, Жаргалант сум/	2018	2020
2	Спорт заалны барилга, 300 суудал /Ховд, Алтай сум/	2021	2022
3	Сургуулийн дотуур байр 100 ор /Ховд Дуут сум/	2022	2023
4	Хөшөөтийн уурхай-Үенч сум 35 кв-ын дэд станц өргөтгөл	2019	2023
5	Халаалтын зуухны өргөтгөл /Зэрэг сум/	2022	2023

Аудитын илрүүлэлт

- Алтай сумын спорт заал: Үнийн өсөлтийн зөрүүгээс төсөвт өртөг нь нэмэгдэх барилга байгууламжийн жагсаалтад орж төсөвт өртгөө нэмэгдүүлж чадаагүй, одоо барилгын ажлыг үргэлжлүүлэх боломжгүй гэсэн тайлбартай
- Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламж тоног төхөөрөмж шаардлага хангахгүй байгаа гэсэн шалтгаанаар
- Дуут сумын дотуур байр үнийн өсөлтийн зөрүүгээс төсөвт өртөг нь нэмэгдэх барилга байгууламжийн жагсаалтад орж төсөвт өртгөө нэмэгдүүлэх саналтай, одоо барилгын ажлыг үргэлжлүүлэх боломжгүй гэсэн тайлбартай
- Зэрэг сумын халаалтын зуухны өргөтгөл авчирсан тогоо таараагүй учир үргэлжлүүлэх боломжгүй,
- Хөшөөтийн уурхайгаас Үенч сум хүртэл 35 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, Үенч дэд станцын өргөтгөл ашиглалтад оруулахгүй байгаа шалтаан, тайлбаргүй

2.4. Захиалагчийн болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллага, улсын комисс төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавиагүй, илэрсэн алдаа зөрчлийг тухай бүр арилгуулаагүй, өгсөн үүрэг даалгаврынхаа хэрэгжилтийг хянахгүй байх зөрчил байсаар байна



Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар он дамжсан, эрх шилжээгүй хөрөнгө оруулалтын 46 төсөл арга хэмжээний хяналтын зардалд 209.6 сая төгрөгийн санхүүжилтэд аймгийн ГХБХБГ нь Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан гэрээний дагуу хамтран захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, илэрсэн зөрчлийг барилга байгууламжийн хяналтын дэвтэрт тухай бүрд нь тусгаж зөрчлийг арилгуулдаг ч явцын хяналтаар илэрсэн зөрчилд өгсөн үүрэг даалгаврын биелэлт

үр нөлөө багатай байна. Захиалагчийн хяналтыг тусгай зөвшөөрөлтэй Дөл бадам ХХК 1 төсөл арга хэмжээнд хяналт хэрэгжүүлж хяналтын цаг тухай тайлагнасан байна.

Эрх шилжиж ирсэн УТХО-ын төсөл арга хэмжээний төсөвт өртгөөс захиалагчийн хяналтын зардалд 491.4 сая төгрөгийг суутган төвлөрүүлсэн байна. ГХБХБГ-т 165.3 сая төгрөгийн

хяналтын зардал олгож 100% хэрэгжсэн 19 төсөл арга хэмжээний 265.6 сая төгрөгийн техник хяналтын зардлаас хяналтын зардалд 165.3 сая төгрөг зарцуулж зарцуулагдаагүй үлдэгдэл 99.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна

Гүйцэтгэлээр ГХБХБГ-ын дансанд эрх шилжиж ирсэн ажлын хяналтын зардалд 165.3 сая төгрөг, эрх шилжээгүй ажлын 44.4 сая төгрөг нийт 209.6 сая төгрөг санхүүжилт олгосноос 23.5 сая төгрөгийг халаалтын зардал, сумдын газрын даамлын томилолтын зардал, газрын тооллогын зардал, үйл ажиллагааны бусад зардлуудад зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын холбогдох заалтыг зөрчиж, барилгын үе шатанд тавих захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

- Дөргөн сумын Чоно харайхын гүүрний ажлын зургийг ГБЭТ ХХК гүйцэтгэсэн бөгөөд уг компанитай зохиогчийн хяналт хийлгэх гэрээ байгуулаагүй бөгөөд хяналт хийгдээгүй,
- Сумын төвийн хатуу хучилттай авто замын /Баатархайрхан, бичигт баг/ ажлын зургийг Гео зураглал ХХК хийсэн бөгөөд зохиогчийн хяналт хийгдээгүй,
- Кино театрын барилга /Ховд, Жаргалант сум/-ын ажил гүйцэтгэгч Чандмань уушир ХХК нь Захиалагчийн болон зохиогчийн хяналтаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг улаан журналд бичээгүй, үе шатны ажлын бүртгэлийг хөтлөөгүй, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй,
- Олон угсаатны театрын барилга /Ховд, Жаргалант сум/-ын ажил гүйцэтгэгч Эрдэнийн шим ХХК нь Захиалагчийн болон зохиогчийн хяналтаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг улаан журналд бичээгүй, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй,
- Техник хяналтын дансанд УТХО-ын данснаас гадна ОНХС, ОНХО, Хөшөөт хөгжил сан зэрэг данснуудаас орлого төвлөрдөг ба данс бүрээр тусдаа тайлагнаж, бүртгэл хөтлөхгүй байгаа нь тус данснаас гарч буй зориулалт бус зардлуудыг УТХО-ын захиалагчийн хяналтад хамааруулж авч үзэх боломжгүй
- Алтай сумын эрүүл мэндийн төвийн барилгыг улсын комисс ажиллан хүлээн авсан боловч дээрээс ус дусалсан, дээррийн ажил чанаргүй хийгдсэн

2.5. Ашиглалтад орсон барилга байгууламж, нийлүүлсэн техник, тоног төхөөрөмж, ашиглалтад хүлээн авсан хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгасан ч зарим ашиглалтад орсон хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүй байна.

Ашиглалтад хүлээн авч ашиглагдаж байгаа эрх шилжсэн 5 төсөл, арга хэмжээний 10.289.8 сая, эрх шилжээгүй 6 төсөл, арга хэмжээний 21.337.4 сая нийт 33.222.1 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, өмнөх онд дууссан 6 ажлын хөрөнгө оруулалтыг 3.039.7 сая төгрөгөөр данс бүртгэлд дутуу тусгасан, Шинэ хөдөө төслийн багцын 5156.0 сая төгрөгийн хөрөнгө нийлүүлээгүй байхад орлого авсан байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт

Ашиглагдаж байгаа хөрөнгө

- ГИХ-ын баруун бүс дэх газрын үйлчилгээний цогцолбор барилга-2389.9 сая,
- Улсын бүртгэлийн хэлтэс, архивын тасгийн байр-5069.6 сая,
- Сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээ, /цэвэр бохир ус, дулаан, дулааны эх үүсвэр Булган сум-7627.8 сая
- Сумын төвийн хатуу хучилттай авто зам Алтай сум-1050.5 сая
- Бизнес инкубатор төв Булган сум-4593.0 сая
- Эрүүл мэндийн төв Алтай сум-606.7 сая
- Хүнс, хөдөө аж ахуйн газар, лабораторийн барилга -2937.4 сая
- Спорт заалны барилга-1441.1 сая

- Эрүүл мэндийн төв Мянгад-1704.1 сая
 - Жаргалант сумын 8-р цэцэрлэгийн өргөтгөл-2107.1 сая
 - Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн багц-12-2100.0 сая
- Хөрөнгөд дутуу тусгасан**
- Дөргөн сумын Чоно харайхын гүүрийг данс бүртгэлд 346.5 сая төгрөгөөр
 - Жаргалант сумын 10-р цэцэрлэг-327.7 сая төгрөгөөр
 - Чандмань сумын ЗДТГ-ын барилга -247.7 сая төгрөгөөр
 - Ховд сумын ЕБС-ийн барилга-648.6 сая төгрөгөөр
 - Жаргалант сумын 9-р цэцэрлэгийн барилга-856.8 сая төгрөгөөр
 - Дөргөн сумын Чоно харайхын гүүрийг-346.6 сая төгрөгөөр
 - Дөргөн сумын ЭМТ-ийн барилга 265.8 сая төгрөгөөр
- Ирээгүй хөрөнгө бүртгэлд тусгасан**
- Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл багц-5156.0 сая төгрөг

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2⁸-д гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул ашиглалтад хүлээн авсан хөрөнгүүдийн баримт бичгийг бүрдүүлэн данс бүртгэлд тусгах, дутуу орлого авсан хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

БҮЛЭГЗ: Зарим барилга байгууламж, техник тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар ашиглаагүй, нийлүүлсэн тоног төхөөрөмж ашиглалтгүй хадгалагдаж байгаа нь төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна

Хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрээгүй, өмнөх онд өгсөн зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна

3.1. Тайлант онд тоног төхөөрөмж нийлүүлэх 2 төсөл, арга хэмжээ болох орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө багц, үйлдвэрлэлийг дэмжих багц 7.259.2 сая төгрөгийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр батлагдсан байна. Өмнөх онуудад болон тайланд онд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүд хувь хүн эзэмшиж байгаа бөгөөд түрээсийн болон ашиглалтын гэрээ хийгээгүй байна.

Аудитын илрүүлэлт

- Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрөөс хэрэгжсэн 75 морины хүчин чадалтай 2ш трактор дагалдах хэрэгслийн хамт Ховд суманд 134.0 сая төгрөг, Булган суманд 125.0 сая төгрөгөөр хүлээлгэн өгсөн бөгөөд хувь иргэн эзэмшиж байгаа, ашиглалтын болон түрээсийн гэрээ хийгээгүй
- Өмнөх онд нийлүүлэгдсэн 120.0 сая төгрөгийн өртөгтэй 3 автобус хувь хүн эзэмшиж байгаа бөгөөд ашиглалтын болон түрээсийн гэрээ хийгээгүй, шугамд явахгүй иргэдэд үйлчилгээ үзүүлэхгүй байна
- Адууны мах боловсруулах үйлдвэрийн 64.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж хувь хүний эзэмшилд байгаа, түрээсийн болон ашиглалтын гэрээ хийгээгүй

3.2. Барилга байгууламж, техник тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар ашиглаагүй нийлүүлсэн тоног төхөөрөмжийн эзэмшигч нь тодорхой бус ашиглалтгүй, хадгалагдаж байгаа нь төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

⁸ "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал бүртгэнэ, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.4-д "Улсын төсвийн тухай хуулийн дагуу хийсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ болон төрийн өмчид хамаарах хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон эд хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн зэцсийн гүйцэтгэлийн дүнгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж эргэлтийн болон үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд заавал тусгана."

Аудитын илрүүлэлт

- ХХААХҮС-ын багцаас Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж, орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд тоног төхөөрөмж нийлүүлэх 1580.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 багц ажлын тоног төхөөрөмж агуулахад хадгалагдаж байгаа
- Өмнөх онуудын хөрөнгө оруулалтаар дуусаагүй барилгын жагсаалтад бүртгэгдсэн Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламжийн барилга байгууламж тоног төхөөрөмжийн шаардлага хангахгүй асуудлаас үүдэн ашиглалтад ороогүй
- Өмнөх онд хэрэгжсэн 1000 тонны хүчин чадалтай ногооны зоорь зориулалтын дагуу ашиглаагүй барааны агуулах хэлбэрээр ашиглаж байгаа
- Өмнөх онд хэрэгжсэн 145.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ус шахах тоног төхөөрөмж нийлүүлэх ажил хугацаандаа хэрэгжиж, нийлүүлэгч аж ахуйн нэгж тоног төхөөрөмжөө хүлээлгэн өгсөн боловч ашиглагч байгууллага, иргэн тодорхой бус шалтгааны улмаас гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн агуулахад хадгалагдаж байгаа
- Өмнөх онд хэрэгжүүлсэн 396.9 сая төгрөгийн санхүүжилттэй Мөст сумын түүхий эдийн барилга үйл ажиллагаа явуулаагүй, хүлээн авсан актгүй, данс бүртгэлд тусгагдаагүй, ашиглалтгүй

3.3. Гүйцэтгэгч төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийг гаргаж ирүүлсэн тухай бүр системийн дээд байгууллагаас хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрхийг нээж өгсөн байна.

Засгийн газрын шийдвэрээр харьяа сайдуудын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын зарим ТАХ-г хуульд заасны дагуу ХАА-г зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, санхүүжүүлэх, тайлагнах эрхийг засаг даргад олгосон байна.

3.4. Зарим хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын өмнөх оны аудитаар өгөгдсөн 375.0 сая төгрөгийн албан шаардлага, 4,951.9 сая төгрөгийн зөвлөмж өгөгдсөн нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийгдэж байгаа хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Тайлант онд Засаг даргад эрх шилжүүлсэн 24 төсөл арга хэмжээ байгаагаас 12 төсөл арга хэмжээг бүрэн дуусган хүлээн авч, 2 төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг хэсэгчлэн хүлээн авч, 3 төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжүүлээгүй, 7 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжихээр байна.

Бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэн, гэрээний үүргийн биелэлтийг Засгийн газрын 2021 оны 278 дугаар тогтоолын дагуу тооцон ажиллах шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын гэрээ байгуулаад гэрээний үүргээ биелүүлээгүй барьцаа дансанд санхүүжилт нь байршсан 509.1 сая төгрөг, гэрээний дагуу ажлаа эхэлсэн ч ажлаа дуусгаж хүлээлгэн өгөөгүйгээс санхүүжилтээ бүрэн аваагүй 328.1 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт

- Дөргөн сумын 10 ортой эрүүл мэндийн төвийн барилга нь 2023 онд ашиглалтад орсон боловч хананд цууралт өгсөн, барилгын чанар, стандарт алдагдсан байж болзошгүй байна. Мөн гадна тохижилтын ажил дутуу хийгдсэн
- Мянгад сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажил дуусаж ашиглалтад хүлээн авсан бөгөөд гадна тохижилтын ажил бүрэн хийгдээгүй байна.

Гэрээ байгуулсан ч ажлаа хийгээгүй

- ЭМС-ийн багцаас Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн явуулын амбулаторийн автомашин нийлүүлэх 428.0 сая-2022
- Барьцаа төлбөрийн үлдэгдэл-5.0 сая-2019
- Сум багуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийн 19.9 сая-2021
- ХНХЯ-ны ХӨИХ түр хамгаалах байр их засвар 14.1 сая-2021

- Шинэ хөдөө төсөл худаг гаргах 32.0 сая-2021
 - Малчид ОНХХ-ийг дэмжих 9.8 сая
- Гэрээний дагуу ажлаа бүрэн хийж хүлээлгэн өгөөгүй
- Өмнөх онд дутуу хэрэгжсэн ЖДҮ дэмжих хөтөлбөрийн багц 57.7 сая-2019
 - Сум багуудын дэмжих хөтөлбөр Цэцэг сумын гэрэлтүүлэг 15.0 сая-2021
 - Сум багуудыг дэмжих хөтөлбөр мотоцикл нийлүүлэх 613.1 мянга
 - Сум багуудыг дэмжих хөтөлбөр Чандмань арьс ширний тоног төхөөрөмж 12.6 сая
 - Зэргийн ИШС-өргөтгөл Зэрэг сум-50.2 сая-2021
 - Сумын төвийн цахилгаан хангамж Манхан сум 96.7 сая-2022

Аудитаар нийт 12.131.988.706 төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 4.798.940.570 төгрөгийн 4 төлбөрийн акт, 2.335.735.183 төгрөгийн 5 албан шаардлага, 4.997.312.953 төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгөгдлөө.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Он дамжин хэрэгжиж байгаа зарим хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хангалтгүй, гүйцэтгэгч тал гэрээний үүргээ биелүүлээгүй, захиалагч тал гэрээний биелэлтийг тооцож ажиллаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн Аймгийн Засаг дарга Э.Болормаа -д зөвлөх нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний гэрээний үүргийн биелэлтийг тооцож, хэрэгжихгүй байгаа болон хугацаандаа хүлээлгэж өгөхгүй байгаа гүйцэтгэгч байгууллагуудтай хариуцлага тооцох

Санхүү Төрийн Сангийн хэлтсийн дарга Ч.Багдал-д

1. УТХО-ын болон ОНХО-аас хэрэгжиж байгаа ТАХ-ны техник хяналтын зардлыг эх үүсвэр бүрээр бүртгэл хөтөлж, зарцуулагдаагүй үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх
2. УТХО-ын барьцаа хөрөнгийн дансанд байгаа хэрэгжээгүй төсөл арга хэмжээний санхүүжилтийн тооцоо хийж буцаан төвлөрүүлэх

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэбат-т

1. Цаашид захиалагч барилга угсралтын ажилд зохиогчийн хяналт гүйцэтгүүлэх гэрээг зураг төсөл зохиогч компанитай байгуулж, зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэн гэрээний хэрэгжилтийг хангуулж, барилга угсралтын ажлын үе шат бүрд дүгнэлт гаргуулж, үр дүнг тооцон зохих санхүүжилтийг олгож байх.
3. Байнгын ашиглалтад оруулах комиссоос өгсөн үүрэг даалгаврыг эргэн хянаж, биелэлтийг тухай бүр нь хангуулах, ТАХ ажлын гүйцэтгэлийг бүрэн хэрэгжүүлсэн үед улсын комиссын актыг баталгаажуулж, эцсийн санхүүжилтийг олгож байх.
4. Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр хэрэгжүүлсэн хөрөнгийн үр өгөөж, үр дүнг тооцож, гэрээний биелэлтийг хангуулах

Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч -т

1.Ашиглалтад хүлээн авсан хөрөнгүүдийг баримт бичгийг бүрдүүлэн данс бүртгэлд тусгаж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах.

2.Өмнөх онд хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн барилга байгууламжийн магадлалаар батлагдсан төсөвт өртгөөр дутуу орлого авсан хөрөнгийг нэмж орлого авах

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б. Төгөлдөр-т,

1.Захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс орон нутагт хэрэгжсэн барилга угсралтын болон их засварын ажлын чанар ашиглалтын шаардлага хангаагүй, барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, норматив, стандарттай нийцэхгүй байгаа зөрчил дутагдлыг арилгуулах

2.Хугацаандаа ашиглалтад орохгүй байгаа барилга байгууламж, төсөл арга хэмжээний гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлж дүгнэлт гаргах, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах арга хэмжээ авах

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР